**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин** 75.6 болж өссөн нь хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 76 нь ажиллагчид буюу хөдөлмөр эрхэлж байгааг харууллаа. Энэхүү үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтмол өсч байгаа нь дараах графикаас харагдаж байна.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН



**Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин** 19.5 болж өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр буурсан нь хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 20 нь эдийн засгийн идэвхгүй байгааг харуулсан байна.


### ЭЗИБТҮВШИН 2013-2018 ОН



### АЖИЛЛАГЧИД

Аймгийн хэмжээнд ажиллагчдын тоо 22040 болж өмнөх оноос 5.52 хувиар буюу 1288 хүнээр буурсан байна. Нийт ажиллагчдын 47.7 хувь буюу 10510 нь эмэгтэйчүүд, 52.3 хувь буюу 11530 нь эрэгтэйчүүд байна. Ажиллагчдын тоо 2015 оноос хойш тогтмол өсч байна.

### Ажиллагчдын тоо



Нийт ажиллагчдын 3.0 хувь буюу 577 нь 15-19 насныхан, 5.0 хувь буюу 1166 нь 20-24 насныхан, 9.0 хувь буюу 2011 нь 25-29 насныхан, 8.0 хувь буюу 1664 нь 30-34 насныхан, 18.0 хувь 3984 нь 35-39 насныхан, 15.0 хувь буюу 3227 нь 40-44 насныхан, 13 хувь буюу 2924 нь 45-49 насныхан, 15 хувь буюу 2101 нь 50-54 насныхан, 5 хувь нь буюу 1204 нь 55-59 дээш насныхан, 9 хувь буюу 2082 нь 60-с дээш насны ажиллагчид байна. 60 болон түүнээс дээш

насны ажиллагчдын 47.7 хувийг эмэгтэйчүүд 52.3 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж байна. Харин 15-19 насны нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүний 88.3 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.



Нийт ажиллагчдыг боловсролын түвшинээр авч үзвэл 20.0 хувь нь суурь боловсролтой, 13.0 хувь нь техник мэргэжлийн дунд, 14.0 хувь нь дээд боловсролтой, 21 хувь бага боловсролтой, 17.0 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол 9.0 хувь буюу 1950 хүн боловсролгүй ажиллагчид байгаа бол магистрын түвшиний боловсролтой ажиллагчид 187 байна.



Ажиллагчдыг эдийн засгийн салбарын ангилалаар дараах хүснэгтэд харууллаа. Нийт ажиллагчдын 66.8 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 2.2 хувь нь уул уурхайн салбарт үүний 94.7 хувь нь эрэгтэйчүүд, 2.1 хувь нь боловсруулах үйлдвэрийн салбарт тэдгээрийн 40.0 хувь нь эмэгтэйчүүд, Бөөнийн болон жижиглэн худалдааны салбарт нийт ажиллагчдын 5.9 хувь, боловсролын салбарт 5.9 хувь тэдгээрийн 57.7 хувийг эмэгтэйчүүд, эрүүл мэндийн салбарт 2.0 хувь тэдгээрийн 91.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж, Төрийн удирдлагын салбарт нийт ажиллагчдын 4.9 хувь буюу 1087 хүн ажиллаж байна.

Ажиллагчид эдийн засгийн салбараар -2019


Ажиллагчид эдийн засгийн салбараар	Хүйс
------------------------------------	------

	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөө аж ахуйн салбарт	14,739	8,165	6,574
Уул уурхай олборлох салбарт	477	452	25
Боловсруулах үйлдэр	465	279	186
Цахилгаан хий дулааны салбарт	619	619	0
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент	56	0	56
Барилгын салбарт	134	134	0
Бөөний болон жижиглэн худалдаа,	1,311	334	977
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	24	24	0
Зочид буудал нийтийн хоолны үйлчилгээ	56	12	44
Мэдээлэл, холбоо	10	0	10
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	660	270	390
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	81	81	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	45	45	0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	1,087	438	649
Боловсрол	1,291	546	745
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	442	36	406
Урлаг, үзвэр, тоглоом наадам	429	71	358
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	109	22	87

### АЖИЛГҮЙ ИРГЭД


Ажиллах хүчний түүвэр судалгаагаар 2019 оны жилийн эцэст 15 ба түүнээс дээш насны ажилгүй иргэдийн тоо 1147 болж өмнөх оноос 72 хүнээр буюу 5.9 хувиар буурсан байна. Энэ нь нийт хүн амын 2.5 хувийг, хөдөлмөрийн насны хүн амын 3.7 хувийг, эдийн засгийн идэвхтэй хүн амын 4.9 хувийг тус тус эзэлж байна. Ажилгүй иргэдийн 73.8 хувь буюу 847 нь эмэгтэйчүүд, 26.2 хувь буюу 300 нь эрэгтэйчүүд байна.

АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ХҮЙСИЙН ХАРЬЦАА  
2019 ОН



Нийт ажилгүй иргэдийн насны бүтцээр авч үзвэл 23.0 хувийг 20-29 насныхан, 15.0 хувийг 30-39 насныхан, 43.0 хувийг 40-49 насныхан, 19.0 хувийг 50-59 насныхан бүрдүүлж байна.

## АЖИЛГҮЙ ИРГЭД НАСНЫ БҮТЦЭЭР 2019 ОН



## АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН

Хүн амын ажил эрхлэлтийг хамгийн гол үзүүлэлт бол ажилгүйдлийн түвшин байдаг. 2019 оны ажиллах хүчний түүвэр судалгаагаар тооцож гаргаснаар ажилгүйдлийн түвшин 4.9 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна.


Энэ нь улсын дундаж үзүүлэлтэй харьцуулахад 5.1 пунктээр, төвийн бүсийн дундажаас 2.7 пунктээр тус тус бага байна. Төвийн бүсийн аймгуудын дунд Дорноговь аймгийн ажилгүйдлийн түвшин 3.9 хувь байгаа нь хамгийн бага, Дархан-Уул аймаг 18.7 хувь байгаа нь хамгийн их үзүүлэлт байна.

Ажил эрхлэлтийн түүвэр судалгаагаар тооцож гаргасан ажилгүйдлийн түвшин бүсээр болон бүсийн аймгуудтай харьцуулсан байдлаар 2016-2019 он

"Аймаг, нийслэл"	2016	2017	2018	2019
Улсын дүн	10.0	8.8	7.8	10.0
Баруун бүс	12.1	10.7	8.9	11.7
Хангайн бүс	10.6	9.8	7.1	8.2
Төвийн бүс	9.2	8.3	7.6	7.6
Дорноговь	9.9	6.1	5.3	3.9
Дундговь	5.1	4.4	5	4.9
Өмнөговь	14.3	16.4	7.3	6.0
Сэлэнгэ	8.1	6.6	5.6	4.7
Төв	2.7	3.2	2.6	4.1
Дархан	15.4	14.2	19.6	18.7
Говьсүмбэр	18.1	7.8	11.7	10.0
Зүүн бүс	11.4	10.4	8.7	11.9
Улаанбаатар	9.1	7.5	7.6	11.0


Аймгийн ажилгүйдлийн түвшинг сүүлийн 5 жилээр улс болон төвийн бүстэй харьцуулан дараах графикт харуулж байна. Улсын дундаж, төвийн бүсийн ажилгүйдлийн түвшин сүүлийн 2 жил буурсан бол тус аймгийн хувьд 2019 онд мөн адил буурсан байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН УЛС БОЛОН БҮСТЭЙ  
ХАРЬЦУУЛСАНААР 2014-2019 ОН



Төвийн бүсийн аймгуудын ажилгүйдлийн түвшинг өнгөрсөн 2018 онтой харьцуулахад Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан, Говьсүмбэр, Дундговь аймгуудад ажилгүйдлийн түвшин 0.1-1.7 пунктээр буурсан бол Төв аймагт 1.5 пунктээр өсчээ. Говьсүмэр аймгийн хувьд ажилгүйдлийн түвшин 1.7 пунктээр буурсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм.

Төвийн бүсийн аймгуудын ажилгүйдлийн түвшин 2018-  
2019 он




Улсын хэмжээнд эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдэл 8.9 хувь, эрэгтэйчүүдийн дунд ажилгүйдэл 11.0 хувь болж өнгөрсөн оноос буурчээ. Дундговь аймгийн хувьд эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин 7.5 хувь болж өссөн бол, эрэгтэйчүүдийн дунд 2.5 хувь болж өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүд 2.7 пунктээр буурсан харин эмэгтэйчүүд 2.8 пунктээр өссөн байна.

он	Улс		Дундговь	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
2015	8.2	6.7	6.2	4.6
2016	11.6	8.2	6.7	3.4
2017	9.6	7.8	5.8	2.8
2018	8.3	7.1	5.2	4.7
2019	11.0	8.9	2.5	7.5


Ажиллах хүчнээс гадуурх хүн ам

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам 7814 болж өнгөрсөн оноос 24.3 хувиар буюу 1525 хүнээр өссөн байна. Энэ нь иргэдийн ажил хайх болон хийж идэвх буурсан байгааг харуулж байна.



Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 70.6 хувийг эмэгтэйчүүд, 29.4 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхгүй хүн амыг насны бүтцээр авч үзвэл 32.0 хувь нь 15-19 насныхан, 8.0 хувь нь 20-29 насныхан, 8.0 хувь нь 30-39 насныхан, 7.0 хувь нь 40-49 насныхан, 8.0 хувь нь 50-59 насныхан, 37.0 хувь нь 60 болон түүнээс дээш насныхан бүрдүүлж байна.

### АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ НАСНЫ БҮЛГЭЭР




Нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амыг боловсролоор нь авч үзвэл 9 хувь нь буюу 698 хүн боловсролгүй, 16 хувь нь буюу 1239 хүн бага, 27 хувь нь буюу 2079 хүн суурь, 23 хувь нь буюу 1817 хүн бүрэн дунд, 11 хувь нь буюу 839 хүн техникийн болон мэргэжлийн, 7 хувь нь буюу 591 хүн тусгай мэргэжлийн дунд, 7 хувь нь буюу 551 хүн дээд боловсролтой байна.



### АЖИЛ ХАЙГЧ ИРГЭН БА АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн ХХҮГазарт бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 448 болж өмнөх оны мөн үеэс 8.0 хувиар 39 хүнээр буурсан байна. Ажил хайгчдын 50.0 хувийг эмэгтэйчүүд 50.0 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

### Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2014-2019 оноор



Ажил хайгч иргэдийн 16.3 хувь нь дипломын болон бакалаврын дээд, 1.8 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 10.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 43.3 хувь нь бүрэн дунд, 18.7 хувь нь суурь, 6.7 хувь нь бага, 2.9 хувь нь боловсролгүй иргэд байна.

### Ажил хайгч иргэд боловсролоор, хүйсээр 2019 он

Боловсрол	Бүгд	Хүйс	
		эрэгтэй	эмэгтэй
Боловсролгүй	13	9	4
Бага	30	15	17
Суурь	84	45	39
Бүрэн дунд	194	101	93
Техникийн болон мэргэжлийн	46	22	24

Тусгай мэргэжлийн дунд	8	5	3
Дипломын дээд болон бакалавр	73	29	44
Бүгд	448	226	224

Аймгийн ХХҮГазрын мэдээгээр 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 612 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 23 хүнээр буюу 3.6 хувиар буурсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 40.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бол эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 11.7 хувь нь ХАА, ан агнуур, ойн аж ахуй, 16.2 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 3.1 хувь нь барилга, 3.9 хувь нь төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, 23.0 хувь нь уул уурхай олборлолт, 23.2 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх, 7.5 хувь нь боловсролын салбар, 1.1 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 0.7 хувь нь цахилгаан эрчим хүч, уур агааржуулалт, 3.6 хувь нь хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн чиглэл, 1.5 хувь нь боловсруулах аж үйлдвэр, 0.2 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 2.0 хувь нь санхүү болон дааьгалын үйл ажиллагаа, 2.0 хувь нь урлаг үзвэр тоглоом наадам, 0.3 хувь нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаанд зуучлагдсан бол үлдсэн хувь нь бусад салбарт зуучлагджээ.

#### АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2019 оны жилийн эцсийн байдлаар

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	72.0	24.0	11.8
Уул уурхай олборлох үйлдвэр	141.0	15.0	23.0
Боловсруулах аж үйлдвэр	9.0	3.0	1.5
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	4.0	0.0	0.7
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	0.0	0.0	0.0
Барилга	19.0	2.0	3.1
Бөөний ба жижиглэн худалдаа	7.0	4.0	1.1
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.0	0.0	0.2
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	0.0	0.0	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	12.0	0.0	2.0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	142.0	71.0	23.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	24.0	7.0	3.9
Боловсрол	46.0	28.0	7.5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	22.0	21.0	3.6
Урлаг, үзвэр, тоглоом наадам	12.0	6.0	2.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	99.0	62.0	16.2
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2.0	2.0	0.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		0.0	0.0
Бүгд	612.0	245.0	100.0

#### ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

**Хөдөлмөрийн дутуу ашиглалт** гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно. Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:


- **Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар

ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ.

- **Ажилгүй хүн** гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм.
- **Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм




Хөдөлмөрийн дутуу ашиглалт 1722 хүн байгаагаас насны бүтцээр нь авч үзвэл 15-19 насны хүн байхгүй, 21 хувь буюу 20-29 насны 355 хүн, 14 хувь буюу 30-39 насны 247 хүн, 33 хувь буюу 40-49 насны 574 хүн, 20 хувь буюу 50-59 насны 343 хүн, 12 хувь буюу 60-с дээш насны 203 хүн байна.




Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг боловсролын түвшингээр нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой хүн 26,8 хувийг, техник мэргэжлийн боловсролтой хүн 26,5 хувийг, дээд боловсролтой хүн 14,8 хувийг, боловсролгүй хүн 10,7 хувийг, бага боловсролтой хүн 9,0 хувийг, тусгай мэргэжлийн боловсролтой хүн 7,3 хувийг, суурь боловсролтой хүн 4,9 хувийг

эзэлж байгаа нь бүрэн дунд болон техник мэргэжлийн боловсролтой хүмүүс ажил хийх боломжтой хир нь ажил эрхэлж чадахгүй байна.



Дундговь аймгийн боломжит ажиллах хүч цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчийг хооронд нь харьцуулж үзвэл.



2019 оны байдлаар ажил эрхлэлтийн зарим нэг үзүүлэлтүүдийг хүснэгт хэлбэрээр оруулав.

**Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд**

Он	Нийт хүн амын тоо	Хөдөлмөрийн насны хүн ам	Ажиллах хүч	Ажиллагчдын тоо	Ажиллах хүчнээс даруурх хүн ам	Бүртгэлтэй ажилгүйчүүд
2010 он	45.9	28.5	24.2	21.8	9224	848
2011 он	45.0	29.1	24.4	22.3	7455	638
2012 он	44.6	29.7	23.4	21.4	7514	828

2013 он	44.4	29.7	21.6	20.2	9272	829
2014 он	44.2	29.5	22.1	20.9	7859	366
2015 он	44.9	29.8	21.2	20.1	7806	512
2016 он	45.5	30.1	22.2	21.1	8043	519
2017 он	46.4	30.5	23.7	22.6	6812	633
2018 он	46.8	30.8	24.5	23.3	6289	487
2019 он	46.4	31.0	23.2	22.0	7814	448

### Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

Он	АХОТ	АХИЕК	ЭЗА	ХЭТ	Ат	ЭЗИБТ
2010 он	84.9	52.7	38.1	76.5	10.1	32.3
2011 он	83.8	54.2	30.6	76.6	8.8	25.6
2012 он	78.8	52.5	32.1	72.1	8.5	25.3
2013 он	72.7	48.6	42.9	68.0	6.3	31.2
2014 он	74.9	50.0	35.5	70.8	5.3	26.6
2015 он	71.1	47.2	36.8	67.4	5.5	26.2
2016 он	73.8	48.8	36.2	70.1	5.5	26.7
2017 он	77.7	51.1	28.7	74.1	4.4	22.3
2018 он	74.8	52.4	25.7	75.6	5.0	20.5
2019 он	74.8	50.0	33.6	71.0	4.9	19.5

АХОТ-Ажиллах хүчний оролцооны түвшин

АХИЕК-Ажиллах хүчний идэвхийн ерөнхий коэффициент

ЭЗА-Эдийн засгийн ачаалал

ХЭТ-Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

АТ-Ажилгүйдлийн түвшин

ЭЗИБТ-Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин

### Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсадын тоо

Он	Хөдөлмөрийн насны хүн ам	Ажиллах хүч	Ажиллагчдын тоо	ХН-ны 1000 хүнд ногдох	
				Ажиллах хүч	Ажиллагчдын тоо
2010 он	28.5	24.2	21.8	849.1	764.9
2011 он	29.1	24.4	22.3	838.5	766.3
2012 он	29.7	23.4	21.4	787.9	720.5
2013 он	29.7	21.6	20.2	727.3	680.1
2014 он	29.5	22.1	20.9	749.2	708.5
2015 он	29.8	21.2	20.1	711.4	674.5
2016 он	30.1	22.2	21.1	737.5	701.0
2017 он	30.5	23.7	22.6	777.0	741.0

2018 он	30.8	24.5	23.3	795.5	756.5
2019 он	32.3	23.2	22.0	718.3	681.1

---

## ТАВДУГААР БҮЛЭГ. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА


### 1. Аж үйлдвэр



Дундговь аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 онд /оны үнээр/ нийт 10445.5 сая төгрөг болсон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 12.0 хувиар буюу 515.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Дээрх өсөлтөнд уул уурхай олборлох аж үйлдвэр 26.3 хувиар, цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж үйлдвэрлэл 2.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, өсөлтийн хувийг Зураг.1-д харууллаа.

Зураг.1

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт,  
өсөлтийн хувь /2000-2019 он/



Мөн тухайн онд өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 5.1 хувиар өссөн байна.


Хүснэгт-1. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/дэд салбараар, сая.төг/

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/ 2018 %
<b>Дундговь-Нийт дүн</b>	<b>3066.5</b>	<b>5005.1</b>	<b>4530.5</b>	<b>4360.8</b>	<b>6349.9</b>	<b>7542.6</b>	<b>7233.1</b>	<b>8097.8</b>	<b>9330.3</b>	<b>10445.5</b>	<b>112.0</b>
<b>Уул уурхайн олборлох аж үйлдвэр</b>	<b>797.31</b>	<b>2427.3</b>	<b>1988.2</b>	<b>1209.5</b>	<b>3098.5</b>	<b>4033.5</b>	<b>2959.9</b>	<b>3049.5</b>	<b>3648.3</b>	<b>4606.3</b>	<b>126.3</b>
Нүүрс	218.6	349.2	342.5	250.6	327.0	393.7	500.6	<b>379.9</b>	427.3	<b>375.4</b>	<b>87.9</b>
Гөлтгөнө	285.0	0.0	0.0	0.0	0.0	876.0	233.6	<b>676.9</b>	654.1	<b>2174.4</b>	<b>332.4</b>
Жонш	293.7	2078.0	1645.7	958.9	2771.5	2763.8	2225.7	<b>1992.7</b>	2566.9	<b>2056.5</b>	<b>80.1</b>
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>801.06</b>	<b>748.9</b>	<b>819.0</b>	<b>1164.7</b>	<b>1264.0</b>	<b>1059.2</b>	<b>1152.9</b>	<b>1170.4</b>	<b>1225.8</b>	<b>1287.8</b>	<b>105.1</b>
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	636.4	595.5	629.9	609.9	649.6	653.6	836.7	<b>879.6</b>	944.0	<b>1016.1</b>	<b>107.6</b>

Хуснэгт маягт үйлдвэрлэл	10.9	10.5	8.2	14.7	13.8	17.6	14.7	19.1	22.4	23.4	104.5
Боловсруулах бусад үйлдвэр	153.7	142.9	181.0	540.1	600.6	388.0	301.5	271.7	259.4	248.3	95.7
<b>Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж</b>	<b>1468.1</b>	<b>1828.9</b>	<b>1723.3</b>	<b>1986.6</b>	<b>1987.4</b>	<b>2449.9</b>	<b>3120.3</b>	<b>3877.9</b>	<b>4456.2</b>	<b>4551.5</b>	<b>102.1</b>
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл	1322.7	1564.1	1420.4	1607.8	1599.5	1947.3	2605.4	3200.4	3773.3	3787.0	100.4
Ус ариутгал ус хангамж	145.4	264.8	302.9	378.8	387.8	502.6	514.9	677.5	682.9	764.5	111.9

2019 оны байдлаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 43.6 хувийг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж, 44.1 хувийг уул уурхайн олборлох аж үйлдвэр, 12.3 хувийг боловсруулах аж үйлдвэр тус тус эзэлж байна. Үйлдвэрийн салбарын бүтцийн өөрчлөлтийг сүүлийн 3 жилээр харууллаа. Зураг.2-т Аж үйлдвэрийн салбарын сүүлийн 3 жилийн бүтцийн өөрчлөлтийг дэд салбаруудаар харууллаа. 2019 оны салбарын бүтцийг өмнөх онтой харьцуулбал боловсруулах аж үйлдвэрийн салбар 12 хувь болж 1 пунктаар, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн үйлдвэрийн салбар 44 хувь болж 4 пунктаар буурсан бол уул уурай олборлох салбар 44 хувь болж өмнөх онтой харьцуулбал 5 пунктаар өссөн байна.Зураг.2

**Аж үйлдвэрийн салбарын бүтэц хувиар**



### 1.1 Уул уурхай олборлох аж үйлдвэр

2019 оны 1 сарын 1-ны байдлаар Дундговь аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл 13 сумын нутагт 98, хайгуулын тусгай зөвшөөрөл 12 сумын нутагт 115, нийт 213 тусгай зөвшөөрөл байгаа бөгөөд эдгээрийн нийт талбайн хэмжээ 783 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 10.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт-2.Ашиглалт хайгуулын зөвшөөрөл олгосон байдал /сумаар/

Сумын нэр	Ашиглалтын тусгай зөвшөөрөл	Хайгуулын тусгай зөвшөөрөл	Бүгд	Талбайн хэмжээ	Газар нутгийн
-----------	-----------------------------	----------------------------	------	----------------	---------------

	тоо	Талбай	тоо	Талбай		Мян.га	хэдэн хувийг эзлэх
		Мян.га		Мян.га			
1.Дэлгэрцогт					0	0	0.00
2.Дэрэн			3	6.3	3	6.3	1.73
3.Говь-Угтаал	11	5.1	3	3.9	14	9	3.31
4.Цагаандэлгэр	3	4.4	6	11	9	15.4	4.44
5.Баянжаргалан	29	22.2	11	24.2	40	46.4	14.50
6.Өндөршил	7	30.7	20	142	27	172.7	35.45
7.Гурвансайхан	13	49	13	62.7	26	111.7	20.44
8.Өлзийт	9	19	30	135.1	39	154.1	9.95
9.Хулд	4	4.3	20	126.3	24	130.6	21.44
10.Луус	2	0.2	10	46.7	12	46.9	14.82
11.Дэлгэрхангай	19	8.3	11	55.4	30	63.7	10.24
12.Сайхан-Овоо	1	1.4			1	1.4	0.34
13.Эрдэнэдалай	6	5.8	6	12.5	12	18.3	2.49
14.Сайнцагаан	6	5.3			6	5.3	1.58
15.Адаацаг	3	0.2	1	1	4	1.2	0.36
<b>Дүн/давхардсан тоогоор/</b>	<b>113</b>	<b>155.9</b>	<b>134</b>	<b>627.1</b>	<b>247</b>	<b>783.0</b>	10.5
<b>Давхардаагүй тоогоор</b>	<b>98</b>	<b>155.9</b>	<b>115</b>	<b>627.1</b>	<b>213</b>	<b>783.0</b>	10.5

Ашиглалтын 98 тусгай зөвшөөрлийн 30 нь жоншны, 24 нь нүүрсний /7 орд/, 17 нь гөлтгөний /3 орд/, 5 нь барилгын материалын, 7 нь төмөр-цайрын, 5 нь алтны, 2 нь шохойн чулууны, 1 нь өнгөт металлын, 1 нь бал чулууны, 1 нь литийний, 1 нь перлитын орд газар байна. Эдгээрийг 74 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай-40, хамтарсан хөрөнгө оруулалттай-17, гадаадын 100% хөрөнгө оруулалттай-17 байна.

Хайгуулын 115 тусгай зөвшөөрлийг 92 аж ахуйн нэгж эзэмшиж байгаагийн дотоодын хөрөнгө оруулалттай - 72, хамтарсан хөрөнгө оруулалттай- 8, гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай – 12 аж ахуй нэгж байна.


Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 онд 4606.3 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 26.3 хувиар буюу 958 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.3/

## Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт/сая төг/



Гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг өмнөх онтой харьцуулахад гөлтгөнө биет хэмжээгээр 32 хувиар, мөнгөн дүнгээр 3.4 хувиар буурсан бол нүүрс биет хэмжээгээр 2 хувиар буурч, мөнгөн дүнгээр 12.5 хувиар өссөн, жонш олборлолт биет хэмжээгээр 15.5 хувиар буурч, мөнгөн дүнгээр 28.8 хувиар өссөн байна. /Зураг.4,Хүснэгт.2/

## Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний өсөлт, бууралт /биет хэмжээгээр/



Хүснэгт-3. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Нэр төрөл	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2018 /2017%
Хүрэн нүүрс	мян.тн	14.9	20.3	19	16	16.6	17.6	18.3	15.3	15	12.8	98.0
Жонш	мян.тн	17.3	30.8	16.4	13.5	30	32.6	26.8	11.6	9.8	5.6	84.5
Гөлтгөнө	мян.тн	3	0	0	0	0	12.7	7.3	38.1	25.9	16.1	68.0

## 1.2 Боловсруулах аж үйлдвэр

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 онд 1287.7 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 5.1 хувиар өссөн байна. Тус салбарын энэхүү өсөлтөнд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулбал 7.6 хувиар, хүснэгт маягт үйлдвэрлэл 4.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин боловсруулах үйлдвэрийн бусад үйлдвэрлэл 4.3 хувь буюу 11.1 сая.төгрөгөөр буурсан байна. / Зураг.5 /



Гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх онтой харьцуулахад хүснэгт маягт, талх, бялуу, архи, ундаа, хиам, тараг, ааруул, модон эдлэл үйлдвэрлэл өссөн бол нарийн боов, чихэр, цэвэр ус, гоймон, хэрчсэн гурил, вакум цонх хаалга, оёдол эсгүүр үйлдвэрлэл буурсан үзүүлэлттэй байна. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг сүүлийн 10 жилээр өсөлт бууралтыг хүснэгт-4 д харууллаа

Хүснэгт 2. Боловсруулах аж үйлдвэрийн гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл


Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/ 2018
Хүрэн нүүрс	мян.тн	14.9	20.3	19	16,0	16.6	17.6	18.3	15.3	15	12.8	0.85
Жонш	мян.тн	17.3	30.8	16.4	13,5	30	32.6	26.8	11.6	9.8	5.6	0.57
Гөлтгөнө	мян.тн	3	0	0	-	0	12.7	7.3	38.1	25.9	16.1	0.62
Дулааны эрчим хүч	мян.гкал	113.4	79.6	69.4	69.9	68.1	80.7	87.8	101.2	91.2	97	1.06
Түгээсэн цэвэр ус	мян.м3	40.9	70.9	58.7	80	76.4	100.3	89.1	122.3	121.9	140.6	1.15
Сувагжуулалт	мян.м3	26.8	41.2	37.7	44.8	49.8	66.9	67.7	78.3	84.7	93.2	1.10
Хүснэгт маягт	м,х,д,х	156.8	149.7	116.6	210.7	197.1	250.5	210.1	272.9	320.1	334.2	1.04
Талх	тн	116.6	100.6	109.7	75.3	89.5	99.5	115.2	116.8	126.2	147	1.16
Нарийн боов	тн	174.5	107.6	105.4	102.4	93.1	98.7	112.8	115.4	111.5	122.9	1.10
Чихэр	тн	0	0	0	1.5	1.8	2.5	2.5	3.4	3.3	2.9	0.88
Бялуу	тн	0	0	0	0	0.9	2.3	3.7	1.1	2.1	0.4	0.19
Архи	мян.л	70	52.8	44.3	27	18.5	17.1	27.1	27.9	29.3	25.1	0.86
Ундаа	мян.л	6.4	7.5	3.4	4.3	1.6	1.4	2	1.7	8.6	0.2	0.02
Цэвэр ус	мян.л	3.2	5.7	2.1	5	5.7	8.4	7	15.4	24.1	50.3	2.09
Гоймон	тн	4.9	9.2	20.1	28.8	23.8	20.6	20.2	20.4	16.6	10.1	0.61
Хэрчсэн гурил	тн	0	0	0	5	9.4	8.8	9.1	9.6	4.2	3.1	0.74
Хиамны зүйл	тн	4.5	5.1	2.6	4	1.7	1.5	0.4	0.4	0.8	0.5	0.63
Тараг	мян.л	8	5.6	7.6	11.7	18.2	9.3	12.9	5.4	6	9.5	1.58
Хоормог	мян.л	1.2	2.5	2.7	1.1	0.6	0.2	0.7	0.7	0.5	0.8	1.60
Ааруул	тн	1.3	1.2	2.4	0.7	1.5	1.6	1.1	0.9	3.3	1.2	0.36
Вакум хаалга, цонх	м <sup>2</sup>	800	610	550	493	812	331	500	220	207	325	1.57
Блок	мян.ш	21.8	11.6	8.5	45.6	78.6	28.7	41.6	20	7.2	5.4	0.75
Оёдол эсгүүр	мян.төг	11916	13059	24379	281756	194144	76204	92103	67765	54427	27685	0.51
Модон эдлэл үйлдвэрлэл	мян.төг	36205	47860	89201	120714	144975	214948	208273	102643	151560	125471	0.83

Боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийг бүтцээр нь авч үзвэл хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл 78.9 хувь, хэвлэх үйлдвэр 1.8 хувь, боловсруулах үйлдвэрийн бусад салбарын үйлдвэрлэл 19.3 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад хүнсний үйлдвэрлэлийн эзлэх хувь 1.9 пунктээр, хүснэгт маягт үйлдвэрлэлийн эзлэх хувь өөрчлөгдөөгүй бол харин боловсруулах үйлдвэрлэлийн бусдын эзлэх хувь 1.8 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн боловсруулах бусад салбарын үйлдвэрлэлийн дийлэнх хувийг жижиг дунд бизнес эрхлэгчид бүрдүүлж байна. Монгол улсын төрөөс жижиг дунд үйлдвэрлэгчидийг дэмжих зорилгоор тогтмол хэрэгжүүлдэг сангуудын мэдээллийг харвал “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онд тус аймагт зээл олгогдоогүй бөгөөд Жижиг дунд үйлдвэрийн бодлогын сангаас 2017 онд 1 ААН 1 төсөл, 2018 онд 2 ААН 2 төсөлд нийт 900 сая төгрөгийн зээл авсан байна. 2019 онд тус аймагт “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан” –аас 1 тэрбум төгрөг хуваарьлагдаад байна.

Сум	2018 он				2019 он			
	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр	төслийн тоо	зээлийн хэмжээ /мян.төг/	Шинэ ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
Сайнцагаан	20	318,200	30	26	21.0	430,000.0	27.0	82.0
Луус	1	20,000	-	1	4.0	62,000.0	2.0	28.0
Хулд	8	56,500	8	-	8.0	83,500.0	4.0	4.0
Дэлгэрхангай	-	-	-	-	13.0	136,500.0	18.0	4.0
Сайхан-Овоо	-	-	-	-	8.0	75,500.0	9.0	3.0
Эрдэнэдалай	15	127,000	18	14	6.0	94,000.0	10.0	4.0
Адаацаг	6	65,500	6	-	4.0	80,000.0	3.0	1.0
Дэлгэрцогт	4	40,000	3	1	4.0	50,000.0	3.0	1.0
Дэрэн	-	-	-	-	14.0	105,000.0	8.0	14.0
Цагаандэлгэр	-	-	-	-	11.0	137,000.0	14.0	25.0
Говь-Угтаал	-	-	-	-	3.0	35,000.0	1.0	2.0
Баянжаргалан	-	-	-	-	7.0	139,700.0	8.0	4.0
Өндөршил	1	10,000	-	1	2.0	20,000.0	5.0	4.0
Гурвансайхан	4	39,000	6	1	11.0	100,000.0	11.0	14.0
Өлзийт	4	37,000	8	4	13.0	116,000.0	22.0	10.0
<b>Нийт</b>	<b>63</b>	<b>713,200</b>	<b>79</b>	<b>48</b>	<b>129.0</b>	<b>1,664,200.0</b>	<b>145.0</b>	<b>200.0</b>

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой Сум хөгжүүлэх сан сүүлийн жилүүдэд тогтмол зээл олгосон байна. Сум хөгжүүлэх сан 2018 онд аймгийн хэмжээнд 63 төсөлд 713.2 сая төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүний үр дүнд 48 ажлын байр хадгалагдаж, шинээр 79 ажлын байр нэмэгджээ. Зураг.6




### 1.3 Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамж

Дундговь аймгийн төв болон 14 сум бүхэлдээ төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон бөгөөд тус аймагт Багануур-Зүүн өмнөд бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ ТӨХК-ийн Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ салбар ажиллаж байна. Дулаан хангамжийн хувьд аймгийн төв Сайнцагаан сумын аж ахуй нэгжүүд болон аймгийн айл өрхийн хэрэглэгчдэд Ган-Илч ХХК,

Тэвшийн говь ХХК болон Дундговь-Ус ОНӨУҮГ, Ариунболор ХХК-ууд дулаан үйлдвэрлэн түгээж байна. Мөн аймгийн нийт 14 сумаас 12 сум нь төвлөрсөн халаалтын системд холбогдоод байгаа бөгөөд үүнээс 6 суманд Ган-Илч компани дулаанаар ханган ажиллаж байна.

Дундговь аймгийн төв болон 14 сумын нийт хүн амын цэвэр усны хэрэглээг газрын гүний усаар хангаж байна. Тус аймгийн усан хангамж болон цэвэр бохир усны хангамж ариутгалын салбарт Дундговь-Ус ОНӨУГ дангаараа үйл ажиллагаагаа явуулж аймгийн иргэдийн эрэлт хэрэгцээг ханган ажиллаж байна. Дундговь –Ус ОНӨУГ нь Дундговь аймгийн төв Сайнцагаан сумын хүн ам, албан газар, аж ахуй нэгжийг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэрлэн халдваргүйжүүлэх, нийтийн халуун усны ашиглалт, 2.1, 0.5 мв хүчин чадалтай нам даралтын зуухны ашиглалтыг хариуцаж дулаан үйлдвэрлэх түгээх үйлчилгээг холбогдох тусгай зөвшөөрлүүдийн дагуу хариуцан ажилладаг 100 хувийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар юм.

Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбар 2019 онд 4551.5 сая төгрөгт хүрч өмнөх оноос 2.1 хувиар буюу 95.4 сая төгрөгөөр өссөн байна. /Зураг.7/



Мөнгөн дүнгээр авч үзвэл өмнөх онтой харьцуулахад дулаан үйлдвэрлэл 3787.0 сая төгрөгт хүрч, 0.4 хувь буюу 13.7 сая төгрөгөөр, усан хангамж ариутгал 764.5 сая төгрөгт хүрч 11.9 хувиар буюу 81.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Салбарын гол нэр төлийн бүтээгдэхүүнийг биет хэмжээгээр өмнөх онтой харьцуулвал сувагжуулалт 10.0 хувиар өссөн бол дулааны эрчим хүч 6.4 хувиар, түгээсэн цэвэр ус 15.3 тус тус өссөн байна.

Хүснэгт-7. Цахилгаан дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж												
Дулааны эрчим хүч	мян.ккл	113.4	79.6	69.4	69.9	68.1	80.7	87.8	101.2	91.2	97	106.4
Түгээсэн цэвэр ус	мян.м3	40.9	70.9	58.7	80	76.4	100.3	89.1	122.3	121.9	140.6	115.3

## 2. Барилга



Дундговь аймгийн хэмжээнд 2019 онд 146164.5 сая төгрөгийн барилга угсралт их засварийн ажил хийгдэж, өнгөрсөн онтой харьцуулахад 15 дахин өссөн байна. Энэ онд 145466.5 сая төгрөгийн барилга угсралтын ажил, 698.0 сая төгрөгийн их засварын ажил хийжээ. /Зураг.8.1.2/



2019 онд 4285.0 сая төгрөгийн орон сууцны барилга, 678.2 сая төгрөгийн худалдаа үйлчилгээний зориулалттай барилга, 1872.0 сая төгрөгийн эмнэлгийн зориулалттай барилга, 3272.1 сая төгрөгийн цэцэрлэгийн барилга, 4062.5 сая төгрөгийн сургуулийн барилга, 3739.0 сая төгрөгийн конторын барилга, 728.3 сая төгрөгийн орон сууцны бус бусад барилга, 125760.0 сая төгрөгийн эрчим хүчний зориулалттай барилга, 944.8 сая төгрөгийн соёлын зориулалттай барилга, 124.4 сая төгрөгийн бусад /зам талбайн/ ажил, 698.0 сая төгрөгийн орон сууцны бус их засварын ажил хийгдсэн байна.

**Хүснэгт-8. Дундговь аймгийн барилга угсралт, их засварын ажлын бүтэц /сая.төг/**

№	Барилгын төрөл	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2018/2017 хувь
1	Орон сууцны барилга	4110.3	557.7	1950.0	1620.0	700.0	3485.0	497.9
2	Орон сууцны барилга, гарааштай	3032.0	400.0	0.0		0.0	800.0	-
3	Худалдаа, үйлчилгээний	768.4	1436.7	4033.2	1462.3	3330.5	678.3	20.4
4	Эмнэлэг	376.0	861.0	179.3	300.0	1350.0	1872.0	138.7
5	Цэцэрлэг	2122.8	258.5	0.0	-	-	3272.1	-
6	Сургууль	2260.6	4818.0	130.0	-	1509.9	4062.5	269.0
7	Соёлын	1140.0	2280.7	599.5	-	-	944.8	-
8	Спорт, биеийн тамир	187.7	1562.5	0.0	-	629.0	-	-
9	Конторын	1117.1	809.5	1460.5	80.3	85.0	3739.0	-
10	Орон сууцны бус бусад барилга	731.1	1259.2	376.6	459.7	1254.2	728.4	58.1
11	Эрчим хүчний	4503.8	128.7	195.0	44.9	97.5	125760.0	-
12	Хатуу хучилттай авто зам	0.0	1655.7	413.9	820.7	0.0	-	-
13	Сайжруулсан хөрсөн зам	0.0	1655.7	95.0	-	-	-	-
14	Далан, суваг, шугам	2081.1	453.6	0.0	164.3	15.7	-	-
15	Бусад (бусад зам, талбайн ажил)	1219.7	1886.7	220.3	268.3	-	124.4	-
16	Орон сууцны барилгын их засвар	116.4	0.0	1350.4	169.0	0.0	-	-
17	Орон сууцны бус барилгын их засвар	1734.3	1022.2	0.0	2562.1	543.2	698.0	128.5
18	Инжежерийн барилга байгууламжийн их засвар	397.2	0.0	94.5	52.0	0.0	-	-
	<b>Нийт</b>	<b>25898.6</b>	<b>21046.3</b>	<b>11098.3</b>	<b>8003.6</b>	<b>9515.0</b>	<b>146164.5</b>	<b>-</b>

2019 онд манай аймагт өрнөсөн томоохон бүтээн байгуулалтаас дурдвал Улаанбаатараас Мандалговь чиглэлийн 330 кВ-ын хүчин чадал бүхий 2 дэд станцтай цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил, Дундговь Говийн тэнгэрийн хашаанд Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ийн 3 давхар конторын барилга, Дундговь аймаг, Дэлгэрхангай, Дэрэн сумын 320 хүүхдийн суудал бүхий 2 давхар сургуулийн барилга зэрэг томоохон барилга баригдсан байна.

### 3.Тээвэр холбоо



**Тээвэр** 2019 оны байдлаар зорчигч тээвэр 28.5 мянга болж өмнөх оноос 3.7 хувиар буурч, зорчигч эргэлт мөн 4.4 хувиар буурч 7782.5 мян.хүн.км болсон байна.

Хүснэгт-9. Зорчигч тээврийн мэдээ

Үзүүлэлт	хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018	2019	2019/ 2018
Зорчигч эргэлт	мян.хүн. км	12530.6	5961.7	12004.8	8057.5	8140	7782.5	95.6
Зорчигчид	мян.хүн	30.2	18.8	43.6	29.3	29.6	28.5	96.3
Орлого	мян.төг	53455.6	30757.2	32450.7	31601.5	34092.1	33924.0	99.5

Зорчигч тээврийн орлого 33.9 сая төгрөг болж өмнөх оноос 0.5 хувиар буюу 0.2 мянган төгрөгөөр буурсан байна. /Зураг.9/



**Холбоо:** Дундговь аймгийн хувьд Өлзийт, Дэлгэрхангай сумдаас бусад бүх сумд шилэн кабельд холбогдсон бөгөөд сумдууд шилэн кабель ашиглаж өндөр хурдаар интернэтэд холбогдож байна. Мөн 2019 онд тус аймгийн төвд Харилцаа холбооны салбарын тэргүүлэгч компаниудын нэг Юнител группын Юнивишн компани өрхийн интернэтийн холбоос, телевизийн суваг, суурин утас гурвыг нэгтгэсэн гурвалсан үйлчилгээ Юнивишн IPTV үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн байна. Үүрэн телефоны сүлжээний хувьд юнител, мобиком бүх сумдад, скайтелын сүлжээ 11 сум /Цагаандэлгэр, Өлзийт сумдын сүлжээ ажиллахгүй байгаа/, жимобайл 15 суманд сүлжээтэйг, мобиком компани 15 суманд, юнител компани өөрийн сүлжээтэй Дэлгэрхангай сумаас бусад бүх сумдад 4 жи технологи нэвтрүүлж хэрэглэгчиддээ өндөр хурдны интернет ашиглах боломжийг хангаж өгсөн байна.

Хүснэгт-10. Үүрэн телефоны сүлжээ

Сумд	Мобиком	Скайтел	Юнител	Жи-Мобайл
Дэлгэрцогт	4жи	3жи,	4жи	3жи
Дэрэн	4жи	3жи	4жи	3жи
Говь-Угтаал	4жи	3жи	4жи	3жи
Цагаандэлгэр	4жи		4жи	3жи
Баянжаргалан	4жи	3жи	4жи	3жи
Өндөршил	4жи	3жи	4жи	3жи

Гурвансайхан	4жи	3жи	4жи	3жи
Өлзийт	4жи		4жи	3жи
Хулд	4жи	3жи	4жи	3жи
Луус	4жи	3жи	4жи	3жи
Дэлгэрхангай	4жи	-	3жи	3жи
Сайхан-овоо	4жи	-	4жи	3жи
Эрдэнэдалай	4жи	3жи	4жи	3жи
Сайнцагаан	4жи	3жи	4жи	3жи
Адаацаг	4жи	3жи	4жи	3жи

Холбооны салбарын мэдээгээр 2019 онд тарифын орлого 474.9 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 10.1 хувиар өссөн байна. Интернет цэгээр үйлчлүүлэгчдийн тоо 2637 болж өмнөх онтой харьцуулахад 2 дахин өссөн бол суурин телефон цэгийн тоо 399 болж мөн 14.7 хувиар буурчээ.

Хүснэгт-11. Холбооны мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2018 /2017
Тарифын орлого	сая.төг	259.22	325.2	428.6	366.4	433.8	431.3	474.9	110.1
Үүнээс хүн амын	сая.төг	76.812	99.35	88.6	85.3	74	44.4	93	209.5
Суурин телефон цэг	тоо	695	686	647	640	518	468	399	85.3
Интернет цэгийн үйлчлүүлэгчдийн тоо	тоо	10884	13573	9863	9329	4665	1318	2637	200.1

#### 4.Бизнес регистрийн сан.


Статистикийн хэлтсийн бизнес регистрийн санд 2019 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 1118 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаа нь өнгөрсөн оноос 5.7 хувиар өссөн үзүүлэлт байна. Үүнээс 544 төрийн бус байгууллага, 161 төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 705 ААНБ байна. Нийт аж ахуй нэгжийг үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар хүснэгт-11. д харууллаа.

Сумдын нэр	Үйл ажиллагаа явуулж байгаа		Үйл ажиллагаа эхлээгүй		Үйл ажиллагаа түр зогсоосон		Үйл ажиллагаа бүрэн зогсоосон		Олдохгүй байгаа болон бусад		Нийт	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Дундговь нийт	663	705.	183	219.	173.	149.	36.	43.	2.	2.	1,057.	1,118.
Дэлгэрцогт	20	20.	3	3.	0.	0.	1.	1.	0.	0.	24.	24.

Дэрэн	16	17.	3	2.	1.	0.	2.	3.	0.	0.	22.	22.
Говь-Угтаал	18	18.	3	5.	3.	3.	0.	0.	0.	0.	24.	26.
Цагаандэлгэр	15	15.	4	5.	0.	0.	1.	1.	0.	0.	20.	21.
Баянжаргалан	22	21.	11	22.	2.	2.	1.	2.	0.	0.	36.	47.
Өндөршил	23	24.	4	6.	14.	14.	1.	2.	0.	0.	42.	46.
Гурвансайхан	22	22.	8	11.	7.	7.	1.	1.	0.	0.	38.	41.
Өлзийт	20	22.	8	13.	5.	3.	2.	2.	0.	0.	35.	40.
Хулд	30	31.	5	6.	9.	7.	1.	1.	0.	0.	45.	45.
Лүүс	18	19.	9	14.	1.	1.	0.	0.	0.	0.	28.	34.
Дэлгэрхангай	26	27.	5	6.	4.	4.	2.	2.	0.	0.	37.	39.
Сайхан-Овоо	31	34.	1	1.	3.	2.	0.	0.	1.	1.	36.	38.
Эрдэнэдалай	37	39.	6	6.	8.	8.	1.	1.	0.	0.	52.	54.
Сайнцагаан	338	370.	112	117.	110.	93.	22.	26.	1.	1.	583.	607.
Адаацаг	27	26.	1	2.	6.	5.	1.	1.	0.	0.	35.	34.


Хүснэгт-12. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт аж ахуй нэгж, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар, сумаар

Нийт ААН-ийн 63,1 хувь нь буюу 705 ААН, байгууллага идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААНБ болон үйл ажиллагаа идэвхтэй явуулж байгаа ААНБ-н тоог сүүлийн жилүүдээр графикт харууллаа. /Зураг.10/



Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагыг салбараар авч үзвэл 20,03 хувь буюу 224 нь бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна. Дэлгэрэнгүйг Зураг.11-т харууллаа.

**Зураг. 11** Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага /эдийн засгийн салбараар, 2019 он



Танилцуулгыг бэлтгэсэн:

Т.Бямбасүрэн

Г.Ариунжаргал

Э. Ган-Очир

Утас: 70593714, 70593715

2020 оны 06 сарын 30  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.ЭНХТУЯА

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

[www.1212.mn](http://www.1212.mn)



Дундговь аймгийн  
статистикийн хэлтэс



[www.dundgovi.nso.mn](http://www.dundgovi.nso.mn)